



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 дугаар сарын 24

Дугаар 02/22

Баян-Өндөр сум

Гамшгийн эрсдэлийг бууруулах орон
нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн ажиллах журам болон холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлд даалгасугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбоотойгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, ажиллах журам батлах тухай” 12/11 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

6125010020



**ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
- Орлогч: - Аймгийн Засаг дарга
- Аймгийн Онцгой байдлын газрын дарга
- Гишүүд: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
- Аймгийн Байгаль орчны газрын дарга
- Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга
- Хотын захирагчийн албаны дарга
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий инженер
- Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
- Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
- Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
- Аймгийн Улаан загалмайн хорооны дарга
- Нарийн бичгийн дарга: - Аймгийн Онцгой байдлын газрын орлогч дарга
- Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн